



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



Хэрэгжүүлэгч :

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



УЛААНБААТАР
2023 ОН



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



Хэрэгжүүлэгч :

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

ХБНГУ-ын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Яам (BMZ)-ны даалгавраар Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ), Боловсрол, Шинжлэх, Ухааны Яамтай хамтран хэрэгжүүлж буй "Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт" төслийн санаачилга, санхүүжилтээр энэхүү судалгааг "Үндэсний судалгаа зөвлөгөөний төв" гүйцэтгэв.



Агуулга

1. Оршил, судалгааны арга зүй.....	3
2. Судалгааны үр дүн: 9 -р ангийн сурагчдын ойлголт	4
2.1 Есдүгээр ангийн сурагчдын шинж чанар.....	4
2.2 Мэдээллийн эх сурвалж, ажил мэргэжлийн чиг баримжаа	5
2.3 Элсэн суралцах шийдвэрт нөлөөлөгч хүчин зүйлс ба ерөнхий боловсролын дараах төлөвлөгөө.....	8
2.4 МБС-ын боловсролын талаарх ойлголт, МБС-ын ажил мэргэжлийн хөдөлмөрийн зах зээлийн үр дүн.....	10
3. МСҮТ, политехник коллежийн оюутнуудын ойлголт	12
3.1 МСҮТ, политехник коллежийн оюутнуудын онцлог	12
3.2 Мэдээллийн эх сурвалж, ажил мэргэжлийн чиг баримжаа	14
3.3 МСҮТ, политехник коллежид элсэхэд нөлөөлсөн хүчин зүйлс болон төгссөний дараах төлөвлөгөө.....	17
3.4 МТ-ийн боловсрол болон хөдөлмөрийн зах зээлийн талаарх ойлголт	21
4. МБС-ын байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл.....	22
4.1 Аймгийн хэмжээнд МБС	22
4.2 МСҮТ-ийн элсэлт	23
5. Дүгнэлт.....	24
6. Бодлогын зөвлөмж.....	25
Үндэсний түвшинд	25
Чадамжийн төвүүд.....	26
Ашигласан материал	27
Хавсралт.....	28

1. Оршил, судалгааны арга зүй

Техникийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалт нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэг чухал хэрэгсэл юм. Гэвч мэргэжлийн боловсрол, сургалт (МБС) буюу техникийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын нэр хүнд олон нийтийн дунд тааруу байгаагаас залуучуудын МБС эзэмших эрэлт, хэрэгцээ хангалтгүй байна. МУ-ын Засгийн газар МБС-ын давуу тал, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор цуврал шинэчлэлийг хөгжлийн түншүүдийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсээр ирсэн (MLSP, 2019). Энэхүү судалгаа нь залуучуудын техникийн болон мэргэжлийн чиглэлээр ажил мэргэжил сонгох шийдвэрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, МБС-ын боловсролын талаар залуучууд хэр ойлголттой байгааг тодруулах зорилготой.

Монгол залуучуудын МБС-ын талаарх ойлголт, ажил мэргэжлийн сонголтыг бид холимог шинжилгээний аргаар судалсан. Хөгжиж буй орнуудад залуучуудын МБС-ын боловсролын талаарх ойлголтыг судалсан ажлууд цөөнгүй байдаг (ASSANEL, 2013; Nath et al., 2019) төдийгүй Монголд ч мөн залуучуудын хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн зах зээлийн талаарх тоон болон чанарын судалгаанууд (RILSP 2018; Schmillen & Sandig, 2018) нэлээд хийгдсэн. Тиймээс судалгааны дизайн болон судалгааны асуулга, удирдамжийг боловсруулахдаа эдгээр судалгааны үр дүн, аргачлалыг ашиглалаа. Судалгаанд Улаанбаатар хот болон Дархан-Уул, Дорнод, Завхан, Өмнөговь зэрэг дөрвөн аймгийн ерөнхий боловсролын 9-р ангийн сурагчид, МСҮТ ба политехникийн коллежийн оюутнууд хамрагдсан. Мэдээлэл цуглуулах ажлыг хоёр үе шаттай хийсэн бөгөөд богино ба дэлгэрэнгүй түүвэр судалгаа болон фокус бүлгийн ярилцлагын арга ашигласан болно. Эхний шатанд судалгаанд хамруулахаар сонгогдсон ЕБС-ийн 9-р ангийн сурагчид болон МБС-ын байгууллагын оюутнуудаас богино хэмжээний түүвэр судалгаа авсан бөгөөд нийт 57 ерөнхий боловсролын сургууль болон МБС-ын байгууллагын 4000 гаруй оюутан, сурагчид хамрагдсан.

Хоёр дахь шатанд фокус бүлгийн ярилцлага (FGD) болон дэлгэрэнгүй судалгаагаар мэдээлэл цуглуулсан бөгөөд энэ шатанд хамрагдах оюутан, сурагчдыг богино судалгааны тоон өгөгдлөөс санамсаргүй түүврийн аргаар сонгосон болно. Залуучуудын ажил мэргэжлийн сонголтын талаар гүнзгийрүүлсэн мэдээлэл цуглуулах зорилгоор нийт 43 фокус бүлгийн ярилцлага хийж, гурван зуу гаруй оюутан, сурагчдаас дэлгэрэнгүй судалгаа авсан. Үүний зэрэгцээ ерөнхий боловсролын сургууль болон политехникийн коллежийн мэргэжилтнүүдтэй ярилцлага хийлээ.

Тайлангийн бүтцийг танилцуулбал, 2-р хэсэгт 9-р ангийн сурагчдын дунд явуулсан судалгааны үр дүн, 3-р хэсэгт МБС-ын байгууллагын оюутнуудын дунд явуулсан судалгааны үр дүнг тус тус танилцуулж, Дөрөвдүгээр хэсэгт бид орон

нутгийн МБС-ын байгууллагууд болон МБС-ын байгууллагын элсэлтийн сүүлийн үеийн хандлагын талаар шинжилсэн бөгөөд 5-р хэсэгт дүгнэлтээ танилцуулж, 6-р хэсэгт судалгааны үр дүнд үндэслэн зарим зөвлөмжийг санал болгосон болно.

2. Судалгааны үр дүн: 9 -р ангийн сурагчдын ойлголт

Судалгаанд Улаанбаатар хот болон Дархан-Уул, Дорнод, Завхан, Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 10 орчим хувийг хамрууллаа.¹ Сонгогдсон дөрвөн аймаг болон нийслэлийн Багахангайгаас бусад 8 дүүргийн нийт 39 ерөнхий боловсролын сургуулийн 3172 есдүгээр ангийн сурагчид судалгаанд хамрагдсан. Мэргэжил сонголтын талаар гүнзгийрүүлсэн мэдээлэл авахын тулд бид эдгээр сурагчдаас 245 сурагчийг санамсаргүй сонгож, дэлгэрэнгүй судалгаанд хамруулсан. Дэлгэрэнгүй судалгаанд хамрагдсан сурагчдын шинж чанарыг сургуулиар нь бүлэглэн хавсралтад үзүүлэв (Хүснэгт А2). Дэлгэрэнгүй судалгаанд хамрагдагсдын 125 (51.0%) нь эмэгтэй, 94 (38.4%) нь МБС-ын талаар мэддэг, 35 (14.3%) нь есдүгээр ангиа төгсөөд МБС-ын байгууллагад элсэн суралцах төлөвлөгөөтэй байна.

Мөн түүнчлэн, богино түүвэр судалгааны тоон өгөгдлөөс санамсаргүй сонгогдсон 158 сурагчидтай нийт 25 фокус бүлгийн ярилцлага хийлээ. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын шинж чанарыг сургуулиар нь бүлэглэн хавсралтад үзүүлэв (Хүснэгт А3). Фокус бүлгийн ярилцлагад хамрагдагсдын 77 (48.7%) нь эмэгтэй, 73 (46.2%) нь МБС-ын талаар мэддэг, 23 (14.6%) нь есдүгээр ангиа төгсөөд МБС-ын байгууллагад элсэн суралцах төлөвлөгөөтэй байна. Дараах хэсэгт богино түүвэр судалгаанд оролцогчдын шинж чанарыг авч үзлээ.

2.1 Есдүгээр ангийн сурагчдын шинж чанар


Хавсралтад буй Хүснэгт А1 болон Зураг 1 нь богино түүвэр судалгаанд хамрагдсан сурагчдын шинж чанарыг харуулна. Тус судалгаанд хамрагдсан сурагчид 13-аас 16 настай бөгөөд улсын дунджаас арай өндөр буюу дунджаар 5.1 ам бүлтэй өрхөд амьдардаг.² Судалгаанд хамрагдсан сурагчдын 1659 (52.3%) нь эмэгтэй бөгөөд 73.5% нь эцэг эхтэйгээ хоёулантай нь, 16.4% нь эцэг, эхийнхээ аль нэгтэй нь хамт амьдардаг. Эцэг эхийн аль алиных нь медиан боловсрол бүрэн дунд байна. Харин ээжүүдийн боловсрол аавынхаас арай өндөр буюу 38.9% нь бакалавр ба түүнээс дээш боловсролтой байна. Аавуудын 94.9% хөдөлмөр эрхэлдэг бол ээжүүдийн 85.7% хөдөлмөр эрхэлдэг. Нийт ээжүүдийн 30.1%, аавуудын 27.0% төрийн албанд ажилладаг. Түүнчлэн

¹ Бид ерөнхий боловсролын сургуулиудыг түүвэрлэхдээ Монголын Статистикийн Мэдээллийн Албаны дунд боловсролын мэдээллийг ашигласан. Аймгуудын хувьд аймгийн төвөөс хоёр, сумаас нэг сургуулийг сонгосон. УБ хотод 284 сургуулиас санамсаргүй түүврийн аргаар 28 сургуулийг сонгосон. Богино судалгаанд анги дүүргэлтээс хамааран 9-р ангийн 2-3 анги оролцсон.


² Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2021 онд нэг өрхийн дундаж хэмжээ 3.7 байна.

ээжүүдийн 30.0% хувийн хэвшилд ажиллаж, 18.7% хувиараа хөдөлмөр эрхэлж, 4.2% нь малчин байсан бол аавуудын 34.8% хувийн хэвшилд ажиллаж, 23.4% хувиараа хөдөлмөр эрхэлж, 6.2% нь малчин хийж байна.


Зураг 1а. Тухайн бүлгийн түүвэрт эзлэх хувь



Зураг 1б. Судалгаанд хамрагдагсад байршлаар



Зураг 1в. Эцэг эхийн боловсролын түвшин



Сурагчдын 20.9% нь МБС-ын байгууллагад өмнө нь суралцаж байсан эсвэл одоо суралцаж байгаа гэр бүлийн гишүүнтэй. Судалгаанд хамрагдсан сурагчдын 70% нь УБ хотод, 23.4% нь аймгийн төвд, 6.6% нь сумын төвд оршин суудаг.


2.2 Мэдээллийн эх сурвалж, ажил мэргэжлийн чиг баримжаа

МБС-ын байгууллага нь элсэн суралцах боломжит бүлэгтээ хүрэхийн тулд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын түгээмэл ашигладаг мэдээллийн сувгуудыг ашиглах нь үр дүнтэй. Богино түүвэр судалгаанд бид сурагчдаас мэдээллийн гол эх сурвалжийнх нь талаар асуусан. Есдүгээр ангийн сурагчдын мэдээллийн гол эх сурвалж Фэйсбүүк бөгөөд 80.3% нь Facebook-ийг сонгосон. Мэдээллийн бусад эх сурвалжийг дурдвал, гэр бүл (31.9%), ТВ (31.1%), найз

нөхөд (28.2%), болон *YOUTUBE* (27.2%) байна. *YOUTUBE* нь эрэгтэй сурагчдын хувьд илүү чухал эх сурвалж бол эмэгтэй сурагчдын хувьд *Instagram* болон гэр бүл нь мэдээллийн чухал эх сурвалж болдог.

Зураг 2. Ажил мэргэжилтэй холбоотой мэдээлийн суваг

Эрэгтэй эмэгтэй сурагчдын аль алиных нь хувьд Facebook хамгийн өргөн хэрэглэгддэг мэдээллийн суваг юм байна.



Тайлбар: Процентуудыг есдүгээр ангийн сурагчдын богино түүвэр судалгааны тоон өгөгдлөөс тооцсон

Дэлгэрэнгүй судалгаагаар бид сурагчдаас карьертай холбоотой мэдээлэл авахад өргөн ашигладаг сувгуудын талаар асуусан. Сурагчид ажил мэргэжилтэй холбоотой мэдээллийг голчлон *Facebook* (69.4%), сургууль (42.9%), гэр бүл (41.6%), болон найзуудаасаа (32.2%) авдаг (Зураг 2) гэж хариулсан. Ажил мэргэжилтэй холбоотой мэдээлэл авдаг гол хэрэгсэл өмнөхтэй адил Фэйсбүүк байсан ч, сургууль болон гэр бүл дараагийн чухал эх сурвалж болсноороо богино түүвэр судалгааны үр дүнгээс ялгаатай байлаа. Сурагчдын тавны нэг орчим нь *YouTube*, *Instagram*, ТВ-ийг ажил мэргэжлийн талаар мэдээлэл авах зорилгоор ашигладаг.

Мэргэжилтнүүдийн ярилцлагаас харахад политехникийн коллежууд сурагчдын өргөн ашигладаг онлайн сувгийн талаар харилцан адилгүй ойлголттой байна.³ Уул уурхай, эрчим хүчний политехник коллежийн хувьд цар тахлын үед хэрэгжүүлсэн онлайн элсэлтээсээ онлайн сувгууд маш үр дүнтэй болохыг ажиглажээ. Мэргэжилтний ажиглалтаар өргөдөл гаргагчдын 70.0 орчим хувь цахим сувгаар мэдээлэл авдаг байна. Уул уурхай, эрчим хүчний политехник

³ Чадамжийн төвийн төлөөлөгчидтэй хийсэн шинжээчийн ярилцлага №3.



коллеж болон техник технологийн политехник коллеж сурталчилгаандаа сургуулийнхаа цахим хуудас болон фэйсбүүк хуудсуудыг идэвхтэй ашигладаг. Гэвч зарим политехникийн коллежууд аман яриа хийх, зорилтот бүлэгтэй уулзалт хийх аргыг ихэвчлэн ашигладаг бөгөөд телевизийн сурталчилгааг илүү үр дүнтэй хэрэгсэл гэж үзэж байна.

Богино түүвэр судалгаанд оролцсон сурагчдын 80.8% нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө авсан гэж хариулсан. Тэдний 94.2% нь гэр бүлийнхээ гишүүнтэй ажил мэргэжлийн талаар ярьсан байна. Ялангуяа, 77.2% нь ээжээсээ ажил мэргэжлийн чиг баримжаа авчээ. 32.2% нь ажил мэргэжлийн талаар найз нөхөдтэйгээ зөвлөлджээ. Түүнчлэн, 59.1% нь нэгээс олон хүнээс мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө авснаас үзэхэд есдүгээр ангийн сурагчид ажил мэргэжлийн сонголтондоо ихээхэн анхаарал хандуулдгийг илтгэнэ. Нийт сурагчдын 12.2 хувь нь МБС-ын байгууллагад элсэн суралцах талаар гэр бүлийнхэнтэйгээ зөвлөлдсөн бол 14.5 хувь нь найз нөхөдтэйгээ зөвлөлджээ.

Дэлгэрэнгүй судалгаанд оролцогчид ажил мэргэжилтэй холбоотой мэдээллийн хүртээмжийг ерөнхийдөө дунд зэргээс хангалттай (71.0%) гэж дүгнэсэн. Гэвч бараг бүгд (94.2%) ажил мэргэжлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах сонирхолтой байлаа. Мэргэжлээ сонгосон сурагчдын хувьд ажил мэргэжлийн эрэлт хэрэгцээ (45.0%), ирээдүйн чиг хандлага (41.1%), давуу тал (38.0%), ажлын олдоц (36.4%), цалин (28.7%), болон сул талын (28.7%) талаар мэдэх хүсэлтэй байна.

Фокус групп 9003-аас: хоёр эмэгтэй, дөрвөн эрэгтэй оролцогч, насны ангилал 14-15, өрхийн дундаж ам бүлийн тоо 4.0.

Оролцогч 3: Тухайн мэргэжилтэй холбоотой гэмтэл бэртлийн талаарх мэдээлэл бидэнд хэрэгтэй. Мөн эрэлт, цалин, орлого, хэр хурдан ажилтай болох талаар мэдээлэл хэрэгтэй. Жишээ нь, хүнд машин жолоодоход хэр хэцүү байдаг зэрэг.

Мэргэжил сонголтоо хийгээгүй байгаа сурагчдаас ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ямар үйл ажиллагаа тэдний шийдвэрт нөлөөлөх талаар асуусан. Сурагчдын бараг тал нь (49.0%) сургууль ажил мэргэжилтэй холбоотой мэдээлэл өгвөл хэрэгтэй гэсэн бол МБС-ын байгууллага, их дээд сургуультай танилцах аялал хэрэгтэй гэж 43.1% нь хариулсан. Сурагчдын гуравны нэг (32.4%) нь мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулбал хэрэгтэй гэж үзсэн.

Фокус группын ярилцлагад оролцогчдын хувьд газар дээр нь очиж танилцах, тухайн сургуулийг төгсөгчид ямар ажил хийдгийг харах, оюутнуудын хийсэн бүтээгдэхүүний жишээ, дээжийг үзэх, ерөнхий боловсролын хичээлийн агуулгад практик дадлагын хэмжээг нэмэгдүүлэх зэрэг нь МБС-ын боловсролыг

сурталчлах үр дүнтэй арга гэж үзжээ. Санал болгосон эдгээр үйл ажиллагаанаас дүгнэхэд сурагчид МБС-ын боловсролын бодит үр дүнг нүдээр харах, үйлдвэрлэлтэй нь танилцах сонирхолтой байгааг илтгэж байна. Фокус группын оролцогсдын МБС-ыг сурталчлах зорилгоор санал болгосон үйл ажиллагаанаас танилцах аялал хамгийн түгээмэл байлаа.

Фокус групп 10001-ээс: Гурван эмэгтэй, гурван эрэгтэй оролцогч, насны ангилал 14-15, өрхийн дундаж ам бүлийн тоо 4.5.

Илтгэгч 1: Оюутнуудыг МСҮТ-д шууд авчирч, давуу талуудын талаар дэлгэрэнгүй ярина. Мөн нээлттэй үйл ажиллагааг зохион байгуулах.

Фокус групп 3001-ээс: таван эмэгтэй, хоёр эрэгтэй оролцогч, насны ангилал 14-15, өрхийн дундаж ам бүлийн тоо 4.9.

Илтгэгч 4: Манай үе тэнгийнхний дунд коллежууд доогуур байдаг гэсэн нийтлэг ойлголтыг өөрчлөх хэрэгтэй. Газар дээрээ (коллеж) үйл ажиллагаагаа нийтэд үзүүлбэл зүгээр.

2.3 Элсэн суралцах шийдвэрт нөлөөлөгч хүчин зүйлс ба ерөнхий боловсролын дараах төлөвлөгөө


Дэлгэрэнгүй судалгаанд оролцогсдын 58.4% нь аль хэдийн мэргэжил сонголтоо хийсэн байна. Мэргэжил сонгоход өөрийн сонирхол хамгийн чухал (81.1%), дараагийн чухал хүчин зүйл нь эцэг эх, гэр бүлийнхний зөвлөгөө (30.8%), гуравдугаарт найз нөхдийн зөвлөгөө (7.6%) гэж тэд үзсэн. *Schmillen and Sandig* (2018)-ийн судалгаанд Монгол залуусын ажил мэргэжлийн сонголтод гэр бүл чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үзсэн байдаг. Бид дэлгэрэнгүй судалгаанд оролцогсдоос мэргэжил сонголтод эцэг эх хэр нөлөөтэй талаар асуусан. Оролцогсдын 49.0% нь эцэг эх хүчтэй эсвэл маш хүчтэй нөлөө үзүүлдэг гэж хариулсан бол зөвхөн 16.3% нь эцэг эхийн нөлөө бага эсвэл нөлөөгүй гэж хариулсан. Яагаад тухайн мэргэжлийг сонгосон талаар асуухад 53.2% нь хоббигоороо, 42.0% нь эцэг эх дэмжсэн болохоор, 35.7% нь өөрийн зан чанар, авьяас чадварт тохирсон учраас, 11.2% нь хувийн бизнестэй болохын тулд, 8.4% нь сургууль дээрээ үзсэн хичээлийн нөлөөгөөр сонгосон гэж хариулжээ.

Богино түүвэр судалгаагаар сурагчдаас есдүгээр ангиа (дунд сургуулиа) төгссөний дараа ямар төлөвлөгөөтэй байгаа талаар асуусан. 78.8 хувь нь үргэлжлүүлэн суралцах төлөвлөгөөтэй байгаа бол 13.2 хувь нь МБС-ын байгууллагад элсэн суралцах төлөвлөгөөтэй байна. Гэхдээ дунд сургуулийн дараах төлөвлөгөөнд хүйсийн эрс ялгаа гарсан. Тухайлбал, бараг таван хөвгүүдийн нэг нь (18.7%) МБС-ын байгууллагад элсэн суралцах төлөвлөгөөтэй байгаа бол 10 охидоос нэг хүрэхгүй нь л (8.1%) ийм төлөвлөгөөтэй байна.

Сургуульдаа үргэлжлүүлэн суралцахаар төлөвлөж буй сурагчдын 3.7% нь арван хоёрдугаар ангиа төгсөөд МБС-ын байгууллагад элсэн суралцах төлөвлөгөөтэй байна.

Зураг 3. МБС-ын байгууллагад элсэн суралцах шалтгаан

Хамгийн чухал шалтгаан нь ажилд орох боломж сайн ба элсэн суралцахад хялбар болон байршил хамгийн чухал биш шалтгаан байна.




Тайлбар: Процентуудыг богино түүвэр судалгааны тоон өгөгдлөөс тооцсон.

Сурагчид янз бүрийн шалтгаанаар МБС-ын байгууллагад элсэн суралцах сонголт хийдэг байна (Зураг 3). Эдгээр сурагчдын бараг тал нь МБС-д хамрагдсанаар ажилд орох боломж ихтэй болдог гэж үзжээ. Дөрөвний нэг нь ажлын байраар дамжуулан гэр бүлийнхээ орлогод хувь нэмэр оруулах зорилгоор МБС-ыг сонгосон бол тавны нэг нь өөрийн бизнестэй болох зорилгоор сонгожээ. Сургалтын байгууллагын байршил, тэтгэлэг, элсэлтийн хялбар байдал, орон нутгийн ажиллах хүчний эрэлт зэрэг нь мэргэжлийн болон техникийн боловсролын сонголтод чухал нөлөөтэй хүчин зүйлс биш байна.

МБС-д элсэн суралцахыг сонгоогүй шалтгаан нь нэлээд олон янз байна. Их, дээд сургуулийн нэр хүнд сайн байгаа нь гол шалтгаан гэж бараг тал нь (43.2%) хариулсан бол МБС-д санал болгож буй мэргэжлийн чиглэл хязгаарлагдмал (19.8%), МБС -ын талаарх мэдлэг дутмаг (17.0%), ажилд орох боломж муу (15.4%) зэрэг нь дараагийн шалтгаан болж байна (Зураг 4). Бусад гэсэн хариултад өөр олон шалтгаан дурдагдсан. Тухайлбал, сурагчдын 7.7% нь эцэг эх зөвшөөрөхгүй, 7.5% нь гадаад явах төлөвлөгөөтэй, 11.9% нь сонирхолгүй учраас сонгоогүй гэсэн байна.

Зураг 4. МБС-ын байгууллагад элсэн суралцахгүй шалтгаан

Гол шалтгаан нь их дээд сургуулийн нэр хүнд ба дараах хоёр шалтгаан нь мэдэхгүй болон мэргэжлийн сонголт хязгаарлагдмал байдаг.



Тайлбар: Процентгь богино түүвэр судалгааны тоон өгөгдлөөс тооцсон.

Фокус бүлгийн ярилцлагаас харахад МБС-ыг ажил мэргэжлийн чиглэлээ болгох талаар эцэг, эхчүүд хүүхэддээ их ялгаатай зөвлөгөө өгдөг байна. Зарим эцэг эхчүүд МБС-ын байгууллагад элсэн суралцахыг эрс эсэргүүцдэг бол зарим эцэг эхчүүд ийм сонголтыг хөхиүлэн дэмждэг байна.

Фокус групп 11003-аас: Гурван эмэгтэй, гурван эрэгтэй оролцогч, насны ангилал 14-15, өрхийн дундаж ам бүлийн тоо 4.8.

Илтгэгч 4: *Эцэг эхчүүдийн дунд түүний (МБС) нэр хүнд маш сул байдаг. Муу дүнтэй гарвал МСҮТ-д явуулна гэдэг.*

Илтгэгч 5: *Ээж, аав хоёр намайг МСҮТ-д мужаанаар сургамаар байна гэж ярьдаг.*

2.4 МБС-ын боловсролын талаарх ойлголт, МБС-ын ажил мэргэжлийн хөдөлмөрийн зах зээлийн үр дүн

Есдүгээр ангийн сурагчдын дунд мэргэжлийн болон техникийн боловсролын талаарх мэдлэг маш дутмаг байна. Богино түүвэр судалгаанаас үзэхэд 37.8 хувь нь л МБС-ын талаар мэдэж байна. Эдгээр сурагчид энэ талаарх мэдээллийг янз бүрийн сувгаар авчээ. Сурагчдын дийлэнх буюу 58.6 хувь нь МБС-ын талаар гэр

бүл болон найз нөхдөөсөө авсан байгаагаас үзвэл эдгээр нь мэдээллийн гол суваг болж байна. Харин 24.5 хувь нь сургуулиасаа эсвэл ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сувгаар мэдээлэл авчээ. Гэр бүл болон найз нөхөд илүү үр дүнтэй суваг болох нь мэдээлэл авсан сурагчдын 16.2 хувь МБС-ын байгууллагад элсэн суралцах төлөвлөгөөтэй байгаагаас харагдаж байна. Түүнчлэн, МБС-ын талаар мэдлэггүй сурагчдын талаас илүү нь энэ талаарх мэдээллийг сонирхож байна. Тухайлбал, эмэгтэй сурагчдын 57.3%, эрэгтэй сурагчдын 48.3% нь энэ талаар мэдээлэл авах хүсэлтэй.

Дэлгэрэнгүй судалгаанд оролцсон МБС-ын талаар мэддэг оролцогсдын хувьд энэ боловсролын гол давуу тал нь мэргэжлийн ур чадвартай болох (61.0%) болон боловсролд зарцуулах хугацаа хожих (50.8%) гэж үзсэн. Тэтгэлэг болон өөрийн бизнестэй болох нь хамгийн бага дурдагдсан давуу тал (16.9%) байлаа. Нөгөө талаас МБС-ын сул талын талаар сурагчдын санал бодол ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, 32% нь ажлын байрны олдоц хязгаарлагдмал, 28.8% нь ажлын байран дээр ахиж дэвших боломж муу, 27% нь хөдөлмөрийн нөхцөл хүнд, 20.3% нь хөрвөх чадвар муу, 16.9% нь цалин багатай гэж үзсэн.

Сурагчдын МБС-ын талаарх ойлголт эрс ялгаатай байна. Тухайлбал, МБС-ын үр өгөөжийн талаар фокус бүлгийн оролцогсдоос асуухад тэдний үзэл бодол эсрэг тэсрэг байх нь олонтаа тохиолдож байв. Зарим оролцогсод маш эерэг ойлголттой байхад, зарим оролцогсод маш сөрөг ойлголттой байсан.

Фокус групп 2003: Гурван эмэгтэй, дөрвөн эрэгтэй оролцогч, насны ангилал 13-15, өрхийн дундаж ам бүлийн тоо 6.1.

Оролцогч 1: Энэ нь өндөр түвшний мэргэжлийн боловсрол олгодог гэж бодож байна.

Оролцогч 5: Намайг 6-р ангид *байхад нөгөө ээлжийн ангийн ах, эгч хоёр ахлах сургуульд үлдэж чадахгүй, коллежед орох нь байна гээд уйлаад орж ирсэн. Тэр цагаас хойш коллежийн тухай бодохоор сэтгэл эвгүй болдог.*

Есдүгээр ангийн сурагчид МБС-ын төгсөгчдийн цалин, ажлын байрны талаар ихээхэн ялгаатай төсөөлөлтэй байна. Тэдний төсөөллөөр медиан цалин 2.5-3.0 сая төгрөг, ажилд орох медиан хугацаа 4-6 сар байна.

Фокус бүлгийн ярилцлагаас дүгнэхэд эцэг эх, багш нарын дунд МБС-ын нэр хүнд маш тааруу байдаг бөгөөд энэ нь сурагчдад тусгалаа олж байна. Эцэг эхчүүдийн хувьд зарим нь МБС-ыг дэмждэг бол зарим нь эрс эсэргүүцдэг. Фокус бүлгийн ярилцлагын үеэр, багш нарын зүгээс чи сайн сурч чадахгүй, биеэ зөв авч явж чадахгүй бол МСҮТ рүүгээ яв гэх зэрэг сөрөг утгатай анхааруулга хэлдэг талаар

сурагчид олонтаа дурдсан. Маш цөөн тохиолдолд багш нар МБС-ын талаар эерэг санал хэлэ, дэмждэг гэж байсан.

Фокус групп 1003-аас: Гурван эмэгтэй, дөрвөн эрэгтэй оролцогч, насны ангилал 14-15, өрхийн дундаж ам бүлийн тоо 4.7.

Оролцогч 3: *Тэд (багш нар) хэрэв чи сайн сурахгүй, 9-р ангиа төгсөж чадахгүй бол чамд тохирох сургууль бий шүү гэдэг.*

3. МСҮТ, политехник коллежийн оюутнуудын ойлголт

Уг судалгаанд Улаанбаатар хот болон Дархан-Уул, Дорнод, Завхан, Өмнөговь аймгууд дахь нийт МСҮТ, политехник коллежийн 42 хувийг хамрууллаа. Нийслэлийн Багахангай дүүргээс бусад дүүрэг болон 4 аймгийн нийт 18 сургуулийн 1 болон 2-р түвшний 1045 оюутан судалгаанд сонгогдсон. Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэй оюутан 402 буюу 38.5 хувийг эзэлж байна. Насны хувьд 14-өөс 18 настай 800 оюутан түүвэрт сонгогдсон нь нийт түүврийн оюутны 76.6 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр оюутны 35.6 хувь нь эмэгтэй байна. Судалгааны үр дүнг бид энэхүү 14-өөс 18 насны оюутнуудын мэдээлэлд үндэслэн боловсрууллаа. Учир нь тэднийг ЕБС-ийн сурагчидтай харьцуулж болох бүлэг гэж үзсэн.

Мэргэжил болон техникийн боловсрол олгох сургалтын байгууллагын оюутнуудын мэргэжил сонголтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор богино түүвэрт хамрагдсан оюутнуудаас 105 оюутныг санамсаргүй сонгож дэлгэрэнгүй асуумж бөглүүлсэн. Дэлгэрэнгүй судалгаанд оролцсон оюутнуудын 76 нь 14-өөс 18 настай бөгөөд эдгээр оюутны 43.4 хувь нь эмэгтэй байна. Энэхүү дэлгэрэнгүй судалгаанд хамрагдсан 76 оюутны ерөнхий шинж чанарын мэдээллийг хавсралтын Хүснэгт В2-т харууллаа. Мөн түүнчлэн, судалгаанд хамрагдсан нийт оюутнаас 105 оюутныг санамсаргүй сонгож фокус бүлгийн ярилцлага хийсэн бөгөөд эдгээр оюутны 43.8 хувь нь эмэгтэй байв. Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан оюутнуудын ерөнхий шинж чанарыг хавсралтын Хүснэгт В3-с харна уу.


3.1 МСҮТ, политехник коллежийн оюутнуудын онцлог

Судалгаанд хамрагдсан оюутнуудын нийгэм, эдийн засгийн шинж чанарыг Зураг 5А-аас 5С-д харууллаа. Нийт судалгаанд хамрагдсан оюутнууд 14-өөс 50 настай байсан ч бид 14-өөс 18 настай оюутнуудын тоон мэдээлэлд шинжилгээ хийлээ. Судалгааны бүлгийн оюутнуудын 35.5% нь эмэгтэй, 51.9% нь эцэг, эхтэйгээ амьдардаг бол 23.2% нь эцэг эсвэл эхийнхээ аль нэгтэй амьдардаг. Боловсролын хувьд оюутнуудын ээжүүд ааваас нь илүү боловсролтой бөгөөд 10% (аавуудын 4.7%) нь бакалавр ба түүнээс дээш боловсролтой байна. ЕБС-


ийн 9-р ангийн сурагчидтай харьцуулахад МСҮТ, политехник коллежийн оюутнуудын эцэг, эх харьцангуй доогуур боловсролтой байна. Мөн түүнчлэн, оюутнуудын аавуудын 89% нь ажил эрхэлдэг бол ээжүүдийн 79% нь ажил эрхэлдэг. Ээжүүдийн 21% нь мал аж ахуй эрхэлдэг бол аавуудын 24% тус аж ахуйг эрхэлдэг ажээ.

Судалгааны бүлгийн оюутнуудын 43.2% гэр бүлийн гишүүдээс нь МСҮТ, политехник коллежид одоо суралцаж байгаа болон өмнө нь суралцаж байсан гэж хариулсан. Энэ нь 9-р ангийн сурагчидтай харьцуулахад хоёр дахин их үзүүлэлт юм. Мөн түүнчлэн, оюутнуудын 33.2% гэр бүлд нь МТ-ийн боловсрол эзэмшсэн хүн байдаг гэж хариулжээ. Оюутнуудын 19.5% нь МСҮТ, политехник коллежид элсэхээсээ өмнө ажил эрхэлж байсан туршлагатай бөгөөд оюутнуудын 10.6% нь 3 сараас бага хугацаанд ажилласан туршлагатай байсан бол 1.8% нь 2 жилээс дээш хугацаанд ажилласан туршлагатай байв. Чадамжийн төв коллежийн оюутнууд нь судалгаанд хамрагдсан нийт оюутны 46.7 хувийг эзэлж байна.


Зураг 5А. МСҮТ, политехник коллежийн оюутнуудын байршил



Зураг 5В. МСҮТ, политехник коллежийн оюутнуудын шинж чанар



Зураг 5С. МСҮТ, политехник коллежийн оюутнуудын эцэг, эхийн боловсрол



Тайлбар: Хувийн жинг богино түүврийн тоон өгөгдлөөс тооцов.


3.2 Мэдээллийн эх сурвалж, ажил мэргэжлийн чиг баримжаа

МСҮТ, политехник коллежийн оюутнуудын 40.4% нь одоогийн сургуульдаа элсэхээс өмнө МТ-ийн боловсролын талаарх мэдээллийг найз нөхдөөсөө авсан гэж хариулсан. Эрэгтэй оюутны 44.1%, эмэгтэй оюутны 33.7% нь найз нөхдөөсөө мэдээлэл авсан гэжээ. Найз нөхдийн дараа орж буй мэдээллийн эх сурвалжууд нь интернет, сошиал медиа байна. Ихэнх оюутан буюу 79.5% нь мэдээллийн нэг эх сурвалж сонгосон.

Оюутнуудын 17.3% нь одоогийн сургуульд элсэхээсээ өмнө илүү сайн мэдээлэл авах хэрэгтэй байсан гэж хариулсан. Тэд сурч буй мэргэжлийнхээ талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл, хөдөлмөрийн зах зээлийн тухай болон хичээлийн хөтөлбөртэй холбоотой мэдээллүүдийг өмнө нь авах хэрэгтэй байсан гэж хариулсан.

Зураг 6. МСҮТ, политехник коллежийн талаар авсан мэдээллийн эх сурвалж

Оюутнуудын хувьд МТ-ийн боловсролын тухай мэдээлэл авсан хамгийн түгээмэл эх сурвалж нь найз нөхөд байна. Дараа нь интернет, социал медиа орж байна.




Тайлбар: Хувийн жинг богино түүврийн тоон өгөгдлөөс тооцов.

Дэлгэрэнгүй асуумж судалгаанд 14-өөс 18 настай 76 оюутан хамрагдсан. Өмнө дурдсанаар шинжилгээг энэ насны бүлэг дээр хийж байгаа билээ. Дэлгэрэнгүй судалгаанд хамрагдсан оюутнуудаас ЕБС-д сурч байхдаа МТ-ийн боловсролын талаар ямар нэг мэдээлэл авч байсан эсэхийг асуусан бөгөөд 46% нь мэдээлэл авсан байсан бол 54% нь үгүй гэж хариулсан. Мэдээлэл авсан гэсэн оюутнуудаас мэдээллийн эх сурвалжийг дэлгэрүүлэн асуухад 37% нь сургуулийн ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа, 37% нь багш нарын хичээлийн үеэр өгсөн мэдээлэл, 27% нь багш нартай ярилцаж үзээд, 20% нь МСҮТ, политехник коллежид очиж мэдээлэл авсан гэжээ. Мэдээлэл авч байгаагүй гэсэн оюутнуудаас ер нь мэдээлэл хайж үзсэн эсэхийг дэлгэрүүлж асуухад 70% нь тийм гэж хариулсан. Ямар төрлийн мэдээлэл сонирхож хайсан тухай асуултад

61% нь тухайлсан мэргэжлийн эрэлтийн талаар, 46% нь сонирхсон мэргэжил нь хэр ирээдүйтэй болох талаар мэдэхийг хүссэн байна.

Зураг 7. Мэдээллийн эх сурвалж, чадамжийн төв болон бусад сургуулийн оюутнууд

Чадамжийн төв сургуулийн оюутнууд бусад сургуулийн оюутнуудаас илүүтэйгээр най: нөхдийг мэдээллийн эх сурвалж хэмээн сонгосон.



Тайлбар: Хувийн жинг богино түүврийн тоон өгөгдлөөс тооцов.

Оюутнуудын МСҮТ, политехник коллежийн талаарх мэдээлэл авсан эх сурвалжийг чадамжийн төвийн сургуулиуд болон бусад сургуулиудаар харьцуулсныг Зураг 7-д харууллаа. Чадамжийн төвийн сургуулийн оюутнуудын тавь шахам хувь нь найз нөхдөөсөө мэдээлэл авсан бол бусад сургуулийн оюутнуудын 33.4% нь найз нөхдөөсөө мэдээлэл авсан байна. Бусад сургуулийн оюутнууд чадамжийн төвийн сургуулийн оюутнуудтай харьцуулахад интернет болон нийгмийн сүлжээг мэдээллийн сурвалжаар арай илүү сонгожээ. Чадамжийн төвийн сургуулиудад сурдаг оюутнуудын 91.4% нь МТ-ийн



боловсролыг найз нөхөд, ойрын хүмүүстээ санал болгоно гэсэн бол бусад сургуулийн оюутнуудын 87.4% нь санал болгоно гэжээ.


3.3 МСҮТ, политехник коллежид элсэхэд нөлөөлсөн хүчин зүйлс болон төгссөний дараах төлөвлөгөө

Дэлгэрэнгүй судалгаанд оролцсон оюутнуудаас одоогийн сурч буй мэргэжлээ ямар шалтгаанаар сонгосныг нь асуухад 67% нь нэг шалтгаан, 13% нь гурван шалтгаан сонгосон бол 12% нь хоёр шалтгаан сонгосон. Хамгийн түгээмэл шалтгаан нь (46%) ээж, аав дэмжиж буй шалтгаанаар сонгосон гэжээ. Дараагийн түгээмэл шалтгаануудад хобби (36.8%), өөрөө бизнес эрхлэх боломжтой учраас (17%), өөрийнх нь авьяас чадварт тохиромжтой учраас (15.8%), өндөр цалин авах боломжтой (14.5%), тухайн мэргэжил эзэмшсэн хүмүүс гоё санагддаг (9.2%) болон өрхийн бизнест хэрэгтэй (5.3%) зэрэг орж байна.

МТ-ийн карьер сонгоход хэн нэгэн нөлөөлсөн үү гэсэн асуултад дэлгэрэнгүй судалгаанд хамрагдагсдын 52.6% өөрийнх нь сонголт гэж хариулсан. Харин 32.7% ээж, 19.7% аав нь шийдвэрт нөлөөлсөн гэжээ. Оюутнуудын карьер сонголтод ээж, ааваас гадна найз нөхөд (14.5%) болон хамаатнууд нөлөөлсөн байна (9.2%).

Зураг 8. МТ-ийн боловсрол сонгосон шалтгаан

Оюутнууд МТ-ийн боловсрол сонгосон шалтгаанууд дунд ажил эрхлэлтийн боломж хамгийн өндөр хувь эзэлж байна. Дараа нь хобби, техникийн сонирхолтой учраас, гэр бүлийн нөлөөгөөр МТ-ийн боловсрол сонгосон гэсэн хариултууд түгээмэл байна.




Тайлбар: Хувийн жинг богино түүврийн тоон өгөгдлөөс тооцов.

МТ-ийн карьер сонгосон шалтгаанууд дунд ажлын байрны олдоц сайтай учраас гэсэн хариулт хамгийн түгээмэл байна. Тодруулбал, богино судалгаанд хамрагдсан оюутнуудын 42.3% нь ажлын байрны олдоц ихтэй учраас МТ-ийн карьер сонгосон гэжээ. Эрэгтэй оюутнуудын 44.1% нь энэ шалтгааныг сонгосон бол эмэгтэйчүүдийн 40.7% нь энэ шалтгааны улмаас уг карьерийг сонгожээ. Ажлын байрны дараа орох түгээмэл шалтгаан нь технологийн сонирхол орж байна.

Оюутнуудын 63.6% нь МТ-ийн карьер сонгосондоо сэтгэл хангалуун байгаа гэсэн бол 31% нь дунд зэрэг гэж хариулсан.

Зураг 9. МТ-ийн боловсрол сонгосон шалтгааныг чадамжийн төв болон бусад сургуулийн оюутнаар харьцуулсан.

Чадамжийн төвийн оюутнууд бусад сургуулийн оюутнуудтай харьцуулахад ажил эрхлэх боломж, гэр бүлийн нөлөө, техникийн сонирхолтой байдал болон хобби гэсэн шалтгаануудыг илүүтэй сонгосон байна.



Тайлбар: Хувийн жинг богино түүврийн тоон өгөгдлөөс тооцов.

Оюутнуудын МТ-ийн карьер сонгосон шалтгааныг чадамжийн төвийн сургуулийн оюутнууд болон бусад сургуулийн оюутнуудаар харьцуулсныг Зураг 9-д харууллаа. Чадамжийн төвийн сургуулийн оюутнууд ажлын байрны боломж, гэр бүлийн нөлөө, технологийн сонирхол болон хобби зэргийг бусад сургуулийн оюутнуудтай харьцуулахад илүү их сонгосон байна. Чадамжийн төвийн оюутнуудын 33.5% нь төгсөөд их сургуульд орох төлөвлөгөөтэй бол бусад сургуулийн оюутнуудын 25.7% нь төгсөөд их сургуульд төлөвлөгөөтэй ажээ. Энэ хоёр бүлгийн бусад төлөвлөгөөний хувьд ялгаа бага байна.

Оюутнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас үзэхэд оюутнуудын одоогийн сургуульдаа сэтгэл ханамжтай байдал янз бүр байгаа нь ажиглагдсан. Гэвч политехник коллежид сурдаг оюутнуудын хувьд ерөнхийдөө сэтгэл ханамж

өндөр байдаг бол жижиг сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд сурдаг оюутнуудын сэтгэл ханамж янз бүр байна.

Фокус бүлгийн ярилцлага 14: Зургаан эмэгтэй оролцогч, насны ангилал 15-18, өрхийн дундаж ам бүлийн тоо 4.6

Оролцогч 1: *Уг нь өнгөрсөн намар анх орж байхад шинэ байрандаа бид нарыг хүлээж авсан. Гэвч энэ жилээс бид нарыг жижигхэн байранд оруулсан. Энд ангиуд нь жижиг учраас олуулаа суугаад эрүүл мэндийн хувьд таатай бус орчинд сурч байна. Сургуулийн зарим багш нар оюутнуудыг ялгаварлан гадуурхдаг.*

Оролцогч 2: *Хүмүүс сургуульдаа сурч чадаагүй, муу хүүхдүүд л МСҮТ-д ордог гэж боддог. Хүмүүсийн энэ ойлголтоос болоод би хааяа МСҮТ-д сурдаг гэдгээ хүмүүст хэлэхээсээ ичдэг.*

Фокус бүлгийн ярилцлага 11: Гурван эмэгтэй, гурван эрэгтэй оролцогч, насны ангилал 15-18, өрхийн дундаж ам бүлийн тоо 4

Оролцогч 1: *Өмнөх сургуулийн багш нар намайг “энэ сургуульд сурч чадахгүй бол тэр МСҮТ-рүүгээ яваарай. Сурч чадахгүй бол чиний байх газар тэр шүү” гэж загнадаг байсан. Би энэ сургуульд ирсэндээ баяртай байгаа. Энэ сургуулийн багш нар нь илүү нээлттэй, практик сайтай, хичээлээ илүү ойлгомжтой заадаг. Би намайг загнадаг байсан багшдаа таны муулаад байдаг МСҮТ-д чинь танаас илүү сайн багш нар байдаг юм шүү гэж хэлэхийг хүсдэг.*

Мэргэжилтнүүдийн ярилцлага 1

Мэргэжилтэн 1. МСҮТ, политехник коллежийн талаарх мэдлэг, ойлголт тааруу байна. Эцэг эхчүүдийн дунд муу сурдаг хүүхэд л МСҮТ-д сурдаг гэсэн хуучны ойлголт байсаар байна. Эцэг эхчүүдэд шаталсан сургалтын системийн сургалтын давуу талын талаар сайн таниулах хэрэгтэй. Бидний хувьд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ажил мэргэжлийн чиг баримжааны сувгийг сайн ашиглаж, хөдөө орон нутагт мэдээллээ түгээж ажиллах дээр анхаарч байна. Манай элсэлт бол сүүлийн жилүүдэд сайжирсан. Монгол ур чадвар гэх мэт тэмцээн, арга хэмжээнүүдийн нөлөөгөөр залуучууд МСҮТ, коллежид элсэх нь нэмэгдэж байна. Цаашид манай сургууль 3,3 минутын богино шторк бэлдэж мэргэжлийн боловсролын сурталчилгаа хийх төлөвлөгөөтэй.

Мэргэжилтэн 2. ЕБС-ийн багш нарын мэдлэг их дутмаг. Шаталсан сургалтын системийн давуу талын талаар ЕБС-ийн багш нарт

мэдээлэл өгөх хэрэгтэй. Бид нар сурталчилгаа, таниулгаа гол төлөв захын сургуулиудаар явж хийдэг. Өмнө нь манайх “Охидын өдөр”, “Хөвгүүдийн өдөр” гэдэг арга хэмжээ зохиодог байсан. Материал бэлдэцээ манайх бэлдээд, сургуулийн сурагчдыг авчирч өөрсдөөр нь бүтээл хийлгэдэг. Энэ арга хэмжээ хүүхдүүдэд хүрэхдээ их үр дүнтэй байсан.

Мэргэжилтний ярилцлага 2

ЕБС-ийн багш нарын хандлага сүүлийн үед сайжирч байгаа. Гэхдээ саяхнаас 10-р ангид квотгүй элсүүлдэг болсон ерөнхий боловсролын бодлогын өөрчлөлтөөс болоод элсэлт буурч эхэлсэн. Эцэг эхчүүд хүүхдүүддээ ерөнхий боловсрол олгохыг илүүд үздэг. Мөн ерөнхий боловсролын сургуулиудын төсвийг хүүхдийн тоотой уясан учраас ЕБС-ийн багш нар аль болох олон хүүхэдтэй байх шаардлагаас үүдэн МСҮТ-ийг сурагчиддаа сурталчлах сонирхолгүй болсон.

Мэргэжилтний ярилцлага 3

Өнгөрсөн жил элсэлт буурсан ч эргээд өссөн. Манай квотууд үргэлж дүүрэн байдаг. Мэргэжил бүр дээрээ манайх 2 ангитай. Энэ ангиуд дандаа дүүрэн элсэлттэй байдаг. Эцэг эхчүүд өөр өөр хандлагатай. Зарим нь хичээлдээ муу хүүхдүүд л МСҮТ-д сурдаг гэдэг хуучны ойлголттой. Зарим нь зах зээлд мэргэжилтэн хомсдолтой байдгийг ойлгодог. Гэр бүлд нь МТ-ийн боловсролтой хүн байдаг хүүхдүүд МТ-ийн боловсролыг сонгодог. ЕБС-ийн багш нарын дунд МТ-ийн боловсролын талаарх хуучин ойлголт давамгайлсаар байгаа. МСҮТ-ийг сахилгагүй, их сургуульд орж чадахгүй хүүхдүүдээ явуулдаг газар гэж хардаг. Манай сургуульд элссэн оюутнуудын 20% нь ийм шалтгаанаар элсдэг. Нэг удаа гэмт хэрэгт холбогдсон сурагчаа эцэг эхтэй нь дагуулаад ирж байсан тохиолдол гарсан. Мөн ЕБС дээр очиход биднийг сурагчидтай уулзуулахгүй гэсэн тохиолдол ч бий. Сургуулийн менежерүүд бид нарыг сайн хүүхдийг нь авчихна гэж айдаг. Учир нь сурагчидтай уулзаад, сурталчилгааны ажлаа хийгээд явахаар тэдний бодол өөрчлөгддөг.

3.4 МТ-ийн боловсрол болон хөдөлмөрийн зах зээлийн талаарх ойлголт

Дэлгэрэнгүй судалгаанд оролцогсдын тавиас илүү хувь нь МТ-ийн карьерийн давуу талыг цаг хугацаа хожих гэж үзжээ. Үүний дараа зах зээлд эрэлттэй мэргэжил эзэмших (32.9%), тодорхой мэргэжил эзэмших (19.7%) болон өөрийн бизнесээ эхлүүлэх боломжтой байдал зэргийг давуу тал гэж үзэж байна. Мөн түүнчлэн, судалгаанд оролцсон оюутнуудын тавин хувь нь өөрийн эзэмшиж буй мэргэжлээрээ ажил амархан олох боломжтой гэж үзсэн. Тэдний 60% нь төгсөөд

өөртөө ажлын байр бий болгох боломжтой, 31% нь төгсөөд өндөр цалин авах боломжтой, 21% нь гэр бүлийн санхүүдээ дэмжлэг үзүүлэх боломжтой болно гэж үздэг байна. Дэлгэрэнгүй судалгаанд оролцсон оюутнуудын 65.8% нь МТ-ийн карьер нь ажлын байран дээрээ өсөж дэвших боломжийг олгодог гэж үздэг бол 32.8% нь МТ-ийн карьер сонгосноор өндөр ур чадвартай мэргэжилтэн болох боломжтой, 34% нь ингэснээр өөрийн бизнестэй болох боломж бүрдэнэ, 33% нь цаашид их сургуульд элсэн суралцах боломжтой болно гэж хариулжээ.

Төгсөөд цаашид хийх төлөвлөгөөний хувьд оюутнуудын 43.9% нь ажилд орох, 29.4% нь их сургуульд элсэх, 9% нь өөрийн бизнес эрхлэх, 12.4% нь өөр мэргэжлээр суралцах төлөвлөгөөтэй байна. Оюутнуудын 7% нь төгсөөд ажилд орвол сарын цалин нь хэд байхаа мэдэхгүй гэсэн бол 27.2% нь 1 саяас 1.5 сая төгрөг, 19.4% нь 1.5 саяас 2 сая төгрөг, 15.7% нь 2 саяас 2.5 сая төгрөгийн цалин авах төсөөлөлтэй байна. Оюутнуудын 28% нь төгсөөд ажилд ороход хэр их хугацаа орохоо мэдэхгүй гэжээ. Харин 19% нь төгсөөд шууд ажилд орно гэсэн бол 32% нь нэгээс гурван сарын дотор ажилд орно гэж үзэж байна.

4. МБС-ын байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны (ХНХЯ) мэдээгээр 2021-ээс 2022 оны хичээлийн жилд нийт 76 бүртгэлтэй МБС-ын байгууллага байна. Өмнө дурьдсанчлан, бид энэхүү судалгаанд дөрвөн аймгийн бүх МБС-ын байгууллага болон УБ хотын сонгогдсон есөн МБС-ын байгууллагыг хамруулсан.

4.1 Аймгийн хэмжээнд МБС

Доорх Хүснэгт 1-д Дорнод, Завхан, Өмнөговь, Дархан-Уул аймгийн МБС-ын байгууллагын мэдээллийг харуулж байна. Нийт 6 политехникийн коллеж, 4 МСҮТ байгаа бөгөөд Өмнөговь аймгийн МСҮТ-өөс бусад нь төрийн өмчийнх байна. МСҮТ нь политехникийн коллежуудыг бодвол хамаагүй жижиг хэмжээтэй. Эдгээр төвүүд нь мэргэжлийн боловсрол, сургалт явуулдаг боловч техникийн боловсрол олгодоггүй. Дорнод аймгийн МСҮТ хамгийн том нь бөгөөд 370 суралцагчтай бол Өмнөговь аймгийн “Скиллстек” төв хамгийн жижиг нь байна. Оюутан суралцагсдын бараг тал нь (43.7%) эмэгтэйчүүд бөгөөд энэ үзүүлэлтээр политехникийн коллежоос хамаагүй өндөр байна.

Хүснэгт 1. Аймгуудын МСҮТ, Политехник коллеж

	Аймаг	сTVET төсөл	Төрийн өмчит	Боловсрол	Оюутнууд		
					Бүгд	Эмэгтэй	Техникийн боловсрол
МСҮТ	Дорнод	Үгүй	Тийм	МБС	370	183	-

Политехникийн коллеж	Дорнод	Тийм	Тийм	ТМС	886	252	207
МСҮТ	Завхан	Үгүй	Тийм	VE	254	122	-
Политехникийн коллеж	Завхан	Тийм	Тийм	ТМС	661	289	126
"Skillstek" МСҮТ	Өмнөговь	Үгүй	ТББ	VE	46	17	-
Политехникийн коллеж	Өмнөговь	Тийм	Тийм	ТМС	845	276	91
"Дабль фиш" ХХК МСҮТ	Өмнөговь	Үгүй	Хувийн	МБС	277	112	-
"Дархан Өргөө" Политехникийн коллеж	Дархан-Уул	Үгүй	Тийм	ТМС	981	291	231
Дархан-Уул аймгийн Политехник коллеж	Дархан-Уул	Үгүй	Тийм	ТМС	698	348	102
Уул уурхай, эрчим хүчний политехник коллеж	Дархан-Уул	Тийм	Тийм	ТМС	840	187	324

Эх сурвалж: Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тайлан: 2021/2022. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Жич: "Скилстек"-ийг ердийн МСҮТ-тэй харьцуулахад маш жижиг хэмжээтэй тул судалгаанд оруулаагүй болно .


Дорнод, Завхан, Өмнөговьд Чадамжийн төвүүдтэй өрсөлдөх политехникийн коллеж байхгүй байна. Харин Дархан-Уул аймагт Чадамжийн төвөөс гадна 2 политехникийн коллеж байдаг ба МСҮТ байхгүй. Бүх политехникийн коллежууд мэргэжлийн боловсрол, сургалт болон техникийн боловсрол олгодог. Политехникийн коллежууд нь оюутны тоогоороо хоорондоо харьцуулагдахуйц бөгөөд 661-ээс 981-ийн хооронд байна. Гурван оюутан тутмын нэг нь эмэгтэй буюу дунджаар 34.4% эзэлж байна. "Дархан- Уул Политехникийн коллеж"-ийн оюутнуудын тал нь (49.9%) эмэгтэй байгаа нь хамгийн өндөр хувь юм. Оюутнуудын тавны нэг нь техникийн боловсрол эзэмшдэг. Харин "Уул уурхай, эрчим хүчний политехник коллеж"-д суралцагсдын 40.4 хувь нь техникийн боловсрол эзэмшиж байгаа нь онцгой өндөр үзүүлэлт юм.

4.2 МСҮТ-ийн элсэлт

МБС-ын байгууллагад элсэгчдийн зонхилох хувийг есдүгээр анги төгсөгчид эзэлж байна (Зураг 8). 2016 оноос өмнө жил тутам арван мянга орчим есдүгээр анги төгсөгчид мэргэжил болон техникийн боловсрол олгодог сургалтын байгууллагад элсэн суралцдаг байсан бол 2016 онд элсэгчдийн тоо огцом буурч, бараг хоёр дахин багассан. Гэвч сүүлийн жилүүдэд есдүгээр анги төгсөгчдийн элсэлт сэргэх хандлагатай байна. 2020 онд есөн мянга гаруй дунд сургууль

төгсөгчид МСҮТ, политехникийн коллежид элссэн нь нийт элсэгчдийн 81.2 хувийг эзэлж байна.

Зураг 10. МБС-ын байгууллагад 9 ба 12 дугаар анги төгсөгчдөөс элсэгчид



Эх үүсвэр: Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын тайлан: 2021/2022. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам.

Дунд сургуулийн тоо (есөн жилтэй сургууль) 2005 оноос хойш тогтмол буурч байна. 2021 оны байдлаар улсын хэмжээнд 109 дунд сургууль байгаа нь 2005 оны тооны талд ч хүрэхгүй, 2011 оны тооны дөрөвний гурвын орчимд байна. Сургуулиудыг есөн жилтэйгээс 12 жилтэй болгож өөрчилсөн нь МБС-ын байгууллагын элсэлтэд нөлөөлж байгааг нотлох баримт бага байна. Сүүлийн жилүүдэд дунд (есөн жилтэй) сургуулийн тоо аажмаар цөөрсөн ч есдүгээр анги төгсөгчдийн элсэлт мэдэгдэхүйц өсчээ.

5. Дүгнэлт

Есдүгээр ангийн сурагчид МБС-ын боловсролын талаар хангалттай мэдээлэлгүй байна. Гэвч тэд МБС-ын талаар мэдэхийг хүсдэг бөгөөд мэдээллийн эрэлт хэрэгцээ өндөр байна. Фокус бүлгийн ярилцлагуудаас эцэг эх, багш нарын дунд МБС-ын нэр хүнд тааруухан байдаг бөгөөд энэ нь сурагчдад тусгалаа олж байна гэж ажиглалаа. Багш нар МБС-ын боловсролын талаар голдуу сөрөг үзэл бодол илэрхийлдэг. Цөөнгүй тохиолдолд эцэг эхчүүд МБС-ыг ажил мэргэжлийн сонголт болгохыг эсэргүүцдэг. Ажил мэргэжлийн талаарх ерөнхий мэдээлэл хүртээмжтэй

бөгөөд сурагчдын анхаарлыг ажил мэргэжлийн сонголт руу хангалттай хандуулдаг. Гэвч цаашдаа тодорхой мэргэжил, тодорхой боловсролын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбар өгөх шаардлагатай байна.

МСҮТ, политехник коллежид сурдаг оюутнуудын ерөнхий нийгэм, эдийн засгийн шинж чанар нь ЕБС-ийн сурагчидтай харьцуулахад нэлээд өөр байна. МСҮТ, политехник коллежийн оюутнуудын эцэг, эхийн боловсрол харьцангуй доогуур бөгөөд ажил эрхлэлт нь ЕБС-ийн сурагчдын эцэг эхтэй харьцуулахад мөн бага байна. МСҮТ, политехник коллежийн оюутнуудын гуравны хоёр нь эрэгтэй. Гэр бүлд нь МТ-ийн боловсролтой хүн байх нь энэ боловсролыг сонгоход нөлөөлөх хандлагатай байна. Тухайлбал, гэр бүлд нь МТ-ийн боловсролтой хүн байгаа гэсэн оюутнуудын хувь ЕБС-ийн сургуулийн ижил хариулт өгсөн сурагчдын хувьтай харьцуулахад 12 (60%) пунктээр илүү байв.

Залуучуудын хувьд МТ-ийн боловсролын талаарх мэдээллийн хамгийн түгээмэл эх сурвалж нь найз нөхөд байна. Оюутнууд МТ-ийн карьерийг сонгохдоо ажлын байрны боломжтой байдлаас үүдэн сонгох нь хамгийн гол шалтгаан байв. Үүний дараа хобби, сонирхол нь нөлөөлж байна. Социалист системийн үед давамгайл байсан МТ-ийн талаарх тааруу төсөөлөл одоо ч эцэг, эх, ЕБС-ийн багш нарын дунд түгээмэл байгаа нь МСҮТ, политехник коллежийн элсэлтэд нөлөөлж байна.

6. Бодлогын зөвлөмж

Судалгааны үр дүнд үндэслэн бид хоёр багц бодлогын зөвлөмжийг боловсруулсан: Үндэсний түвшинд болон чадамжийн төвүүдэд (сTVET) төсөлтэй хамтран ажилладаг политехникийн коллежууд) зориулсан.

Үндэсний түвшинд

1. МБС-ын боловсролын нэр хүндийг олон нийтийн дунд дээшлүүлэхийн тулд залуучуудын сонирхолд нийцсэн, тэдний анхаарлыг татахуйц контент бэлтгэх. Тухайлбал, тодорхой мэргэжлийн чиглэлүүдээр уралдаан, тэмцээн, риалити шоу, үндэсний ур чадварын уралдаан зохион байгуулахыг политехникийн коллежийн мэргэжилтэн санал болгож байсан.
2. Судалгаанаас үзэхэд МБС-ын боловсролын талаарх эцэг эхчүүдийн ойлголт сурагчдын ажил мэргэжил сонгох шийдвэрт маш чухал нөлөөтэй. Тиймээс ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа нь бүх эцэг эх, бүх сурагчдад чиглэхийн зэрэгцээ, бүх боломжит хувилбаруудыг харуулвал зохино. Аливаа бүлэглэлт, зорилтот хүрээг бусад шалгуураар бус зөвхөн оюутны сонирхол, ур чадварт тулгуурлан тодорхойлох нь зүйтэй. Түүнчлэн, ажил мэргэжлийн чиг баримжаа олгохдоо МБС-ын боловсролыг их дээд сургуулиас дор биш адилхан боломжит сонголт гэж танилцуулвал зохимжтой.

3. ЕБС-ийн багш нарын МБС-ын талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх шаардлагатай. Тиймээс ЕБС-ийн багш нарт МБС-ын талаар сурагчиддаа хэрхэн таниулж, мэдээлэл хүргэх талаар сургалт хийх хэрэгцээ байна. Сурагчиддаа МБС-ын талаар эерэг мэдээлэл өгөх хөшүүрэг багш нарт байх шаардлагатай. Үүний тулд багш нарт МБС нь залуучуудын хувьд нэг боломж гэдгийг ойлгуулж, хүлээн зөвшөөрүүлэх хэрэгтэй бөгөөд төгсгөсөн сурагчид дотроос МБС-ын карьер сонгож амжилтад хүрсэн бол тухайн багшийн ажлын гүйцэтгэлд энэ нь эерэгээр нөлөөлдөг байх хөшүүргийг бий болгох шаардлагатай.
4. Сурагчдад ажил, мэргэжлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг болох шаардлагатай байна. Тоон болон чанарын судалгаануудаас оюутан, сурагчдад ажил, мэргэжлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгцээтэй байдаг нь ажиглагдлаа. Ажил мэргэжлийн мэдээллүүдээр судалж буй хичээл нь ямар мэргэжлүүдтэй уялддаг, тухайн мэргэжлийг эзэмшихийн тулд ямар ур чадвар, боловсрол эзэмших шаардлагатай, тухайн мэргэжлийг эзэмших боломжит арга замууд, хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл болон ажил олгогч нарын дунд ямар ур чадвар эрэлттэй байна зэргийг хүргэх хэрэгцээ байна. Хавсралтад Уэлсийн ЕБС-ийн сургуулийн ажил мэргэжлийн мэдээллийн самбарын зургийг харууллаа. Жишээ нь уг самбарт байгаа хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл нь тухайн мэргэжилтэй хүний жилийн дундаж орлого, долоо хоногийн ажиллах цаг, ирэх 3-5 жилд хэдэн ажлын байр гарах боломжтой талаарх үнэлгээ болон тухайн салбарын тэтгэвэрт гарах хүмүүсийн хувь зэрэг мэдээллийг оруулсан байна. Бүлгийн ярилцлагын үеэр оюутан, сурагчдын ярианд олон удаа дурдагдсан нэг зүйл нь сонирхсон мэргэжлийн хувьд ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын талаарх мэдээлэл дутмаг байдаг тухай асуудал байлаа.

Чадамжийн төвүүд

1. Чадамжийн төвүүд залуучуудад хүрэхийн тулд онлайн сувгуудыг, ялангуяа *FB* эсвэл *YOUTUBE* сувгийг үр дүнтэй ашиглах ёстой.
2. *PR*-ийн үйл ажиллагааны агуулга нь оюутнуудад зориулсан товч яриа, ерөнхий мэдээллийн оронд маш тодорхой мэдээлэл агуулдаг, үзүүлэнтэй байх нь зүйтэй.
3. Танилцах аялал зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг урих нь үр дүнтэй.

Ашигласан материал

Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын тайлан: 2021/2022.
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

ASSAHEL зөвлөхүүд, (2013) Эцсийн тайлан: Газын зурвас дахь МБС-д хандах гол оролцогч талуудын хандлагын урьдчилсан судалгаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), НҮБ-ын Боловсролын шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) (2019). *МБС-ын бодлогын тойм: Монгол* .

Nath, SR, Babu, R., Kalam, MA, & Hossain, MA (2019). *Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын (МБС) болон дараагийн ажил эрхлэлтийн талаарх залуучуудын төсөөлөл Бангладешийн зарим сонгогдсон Упазила мужид хийгдсэн суурь судалгаа* .

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны хүрээлэн (ХНХХ), (2018), Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, Улаанбаатар.

Schmillen, A., & Sandig, N.-W. (2018). *Найдвартай байдлын талаарх ойлголт: Монголын хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдлын суурь бэрхшээлүүдийн чанарын судалгаа* . Дэлхийн банк.

Хавсралт

Хүснэгт А1. Есдүгээр ангийн сурагчдын шинж чанар

	Оюутны тоо	Дундаж	Стандарт хэлбэлзэл	Хамгийн бага	Хамгийн их
Оюутнуудын эрин үе	3155	14.4	0.5	13	16
Эрэгтэй оюутнуудын эзлэх хувь	3172	0.5 2	0.5 0	0	1
Өрхийн хэмжээ Ээжүүд	3163	5.1	1.4	1	14
Боловсрол	2180	5.1	1.77	1	8
Хөдөлмөр эрхлэлт	2726	0.86	0.35	0	1
Аав С					
Боловсрол	1877	4.7	1.75	1	8
Хөдөлмөр эрхлэлт	2390	0.95	0.22	0	1
МСҮТ гэр бүлийн боловсролтой	3169	0.21	0.41	0	1
Байршил					
Улаанбаатар	3172	0.70	0.46	0	1
Дархан-Уул	3172	0.07	0.26	0	1
Дорнод	3172	0.07	0.26	0	1
Өмнөговь	3172	0.07	0.25	0	1
Завхан	3172	0.08	0.28	0	1

Тайлбар: Богино түүвэр судалгааны статистикийг энэ хүснэгтэд үзүүлэв. Боловсролын түвшин 8 түвшинтэй бөгөөд "мэдэхгүй" гэсэн сонголттой. 17% нь "мэдэхгүй" гэж хариулсан тул эцэг эхийн боловсролын талаарх ажиглалтын тоо бага байна. Боловсролгүй бол 1, техникийн болон мэргэжлийн боловсрол 5, магистр болон дээд боловсролтой бол 8 байна.

Хүснэгт А2. Дэлгэрэнгүй судалгаанд оролцогсдын шинж чанар, сургуулийн бүлгээр

Сургуулийн бүлэг	Эмэгтэй (%)	Нас	МСҮТ-ийн мэдлэгтэй оюутнууд	МСҮТ-д элсэхээр төлөвлөж буй оюутнууд	НН хэмжээ	Аймаг, Хот	дүүрэг, сум
1001	83	14.3	3	2	5.3	УБ	БГД
1002	33	14.4	0	0	5.5	УБ	БГД
1003	33	13.8	2	0	4.8	УБ	БГД
2001 он	71	14.1	4	2	4.6	УБ	БЗД
2002	67	14.2	1	2	4.8	УБ	БЗД
2003 он	56	13.9	4	3	6.2	УБ	БЗД
2004 он	67	14.3	2	0	5.5	УБ	БЗД
2005 он	57	14.4	0	0	5.0	УБ	БЗД
2006 он	50	14.5	1	1	6.5	УБ	БЗД

3001	33	14.7	3	1	5.8	УБ	SHD
3002	50	14.2	0	0	5.5	УБ	SHD
3003	17	14.2	3	3	6.5	УБ	SHD
3004	14	14.4	4	2	5.1	УБ	SHD
3005	50	14.5	3	1	5.3	УБ	SHD
4001	50	14.5	2	1	6.5	УБ	SBD
4002	50	14.7	0	0	6.0	УБ	SBD
4003	50	14.3	1	1	4.7	УБ	SBD
4004	50	14.5	1	2	4.5	УБ	SBD
4005	29	14.3	4	0	4.3	УБ	SBD
5001	50	14.5	3	0	4.8	УБ	HUD
5002	33	14.3	0	0	4.5	УБ	HUD
5003	100	14.7	1	1	5.3	УБ	HUD
5004	40	14.6	2	0	5.4	УБ	HUD
6001	67	14.5	3	0	5.2	УБ	CHD
6002	17	14.8	1	1	4.8	УБ	CHD
6003	17	14.2	3	1	4.8	УБ	CHD
7001	86	14.6	2	0	5.0	УБ	БНД
8001	50	14.3	3	3	4.7	УБ	NAD
9001	83	14.2	2	0	4.8	Дархан	төв
9002	33	14.3	4	0	4.7	Дархан	төв
9003	57	14.5	2	3	5.9	Дархан	төв
10001	50	14.3	5	1	5.8	Дорнод	төв
10002	50	14.2	4	0	5.0	Дорнод	төв
10003	33	14.5	3	1	4.3	Дорнод	сум
11001	67	14.0	4	0	5.2	Завхан	төв
11002	83	14.7	4	0	4.8	Завхан	төв
11003	67	14.2	4	0	4.3	Завхан	сум
12001	17	14.2	5	3	5.0	Өмнөговь	төв
12002	71	14.3	1	0	5.4	Өмнөговь	сум
Дундаж	50.8	14.4	2.4	0.9	5.2		

Жич: Дүүргийн нэрийг Баянгол (БГД), Баярзүрх (БЗД), Чингэлтэй (ЧД), Сонгинохайрхан (ШД), Хан-Уул (ХУД), Налайх (НАД), Баганур (БНД) гэж товчилсон болно.

Хүснэгт А3. Фокус бүлгийн шинж чанар, сургуулийн бүлгээр

Сургуулийн бүлэг	Эмэгтэйчүүд (%)	Нас	МБС-тай гишүүд мэдлэг	МСҮТ-д элсэхээр төлөвлөж буй гишүүд	Өрхийн хэмжээ	аймаг, Хот	дүүрэг, сум
------------------	-----------------	-----	-----------------------	-------------------------------------	---------------	------------	-------------

1001	17	14.0	3	1	4.7	УБ	БГД
1002	83	14.3	2	1	4.2	УБ	БГД
1003	43	14.1	2	0	4.7	УБ	БГД
2001 он	40	14.2	2	0	4.4	УБ	БЗД
2003 он	43	14.0	3	3	6.1	УБ	БЗД
2005 он	67	14.5	3	0	4.5	УБ	БЗД
3001	71	14.6	2	0	4.9	УБ	SHD
4004	88	14.3	1	0	4.8	УБ	SBD
4005	43	14.4	5	1	5.7	УБ	SBD
5003	29	13.9	2	0	5.0	УБ	HUD
5004	50	14.2	2	0	5.0	УБ	HUD
6003	86	14.3	6	1	5.1	УБ	CHD
7001	33	14.7	3	1	4.8	УБ	над
8001	43	14.3	4	3	5.9	УБ	bnd
9001	50	14.3	5	2	5.2	Дархан	төв
9002	33	14.5	2	1	4.3	Дархан	төв
9003	33	14.2	2	4	6.2	Дархан	төв
10001	50	14.2	2	1	4.5	Дорнод	төв
10002	50	14.8	6	0	5.3	Дорнод	төв
10003	33	14.7	4	1	5.2	Дорнод	нийлбэр
11001	33	14.2	1	0	4.7	Завхан	төв
11002	50	14.5	3	1	5.3	Завхан	төв
11003	50	14.2	3	0	4.8	Завхан	нийлбэр
12001	50	14.5	3	1	4.5	Өмнөговь	төв
12002	33	14.3	2	1	4.7	Өмнөговь	сум
Дундаж	48.0	14.3	2.9	0.9	5.0		

Жич: Дүүргийн нэрийг Баянгол (БГД), Баярзүрх (БЗД), Чингэлтэй (ЧД), Сонгинохайрхан (ШД), Хан-Уул (ХУД), Налайх (НАД), Баганур (БНД) гэж товчилсон болно.

Хүснэгт В1. Оюутнуудын ерөнхий мэдээлэл

	Ажиглалтын тоо	Дундаж	Стандарт хазайлт	Минимум	Максимум
Нас	800	16.071	0.982	14	18
Эмэгтэй оюутну эзлэх хувь	800	0.355	0.479	0	1
Ам бүл	800	5.202	1.585	1	18
Ээж					
Боловсрол	570	3.965	1.408	1	8

Ажил эрхлэлт	570	3.640	1.857	1	6
Аав					
Боловсрол	443	3.711	1.239	1	8
Ажил эрхлэлт	443	3.350	1.722	1	6
Өрхийн гишүүн МТБ-той	296	0.337	0.473	0	1
Ажилласан туршлагатай	800	0.195	0.397	0	1
Чадамжийн төвийн сургуулийнх	800	0.4667	0.5	0	1
Улаанбаатарт	800	0.446	0.497	0	1
Дархан-Уул	800	0.175	0.380	0	1
Дорнод	800	0.153	0.360	0	1
Завхан	800	0.139	0.346	0	1
Өмнөговь	800	0.088	0.283	0	1

Хүснэгт В2. Дэлгэрэнгүй судалгаанд оролцсон оюутнуудын мэдээлэл

Сургуулийн код	Эмэгтэй (%)	Нас		Ам бүл		Байршил	Чадамжийн төвийн статус
		Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй		
11	0.8	15.0	15.0	5.0	4.6	Улаанбаатар	Бусад
12	0.3	15.3	16.0	4.3	5.5	Улаанбаатар	Бусад
13	0.0	18.0		7.0		Улаанбаатар	Бусад
14	0.9	18.0	15.8	6.0	4.5	Улаанбаатар	Бусад
15	0.0	16.0		6.0		Улаанбаатар	Бусад
16	0.5	16.3	16.0	5.7	5.0	Улаанбаатар	Бусад
17	0.3	15.5	15.5	5.3	5.5	Улаанбаатар	Чадамжийн төв
18	0.6	16.5	15.7	5.0	5.3	Улаанбаатар	Чадамжийн төв
19	0.0	17.0		5.8		Улаанбаатар	Чадамжийн төв
21	1.0		15.7		6.0	Дархан	Бусад
22	0.0	17.5		5.0		Дархан	Чадамжийн төв
23	1.0		17.5		4.5	Дархан	Бусад
31	0.2	15.4	16.0	5.4	5.0	Дорнод	Бусад
32	0.3	15.7	15.0	5.0	4.0	Дорнод	Чадамжийн төв
41	0.2	15.2	17.0	5.2	5.0	Завхан	Бусад
42	0.2	15.3	16.0	6.0	5.0	Завхан	Чадамжийн төв
51	1.0		16.0		5.0	Өмнөговь	Бусад
52	0.4	16.0	16.0	4.7	3.0	Өмнөговь	CDC school

Table В3. Фокус бүлгийн оюутнуудын мэдээлэл

Сургуулийн код	Эмэгтэй (%)	Нас		Ам бүл		Байршил	Чадамжийн төвийн статус
		Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй		
11	0.5	16.7	15.3	4.0	4.0	Улаанбаатар	Бусад
12	0.2	15.4	15.0	4.2	3.0	Улаанбаатар	Бусад
13	0.5	33.7	35.0	4.0	4.3	Улаанбаатар	Бусад
14	1.0		16.0		4.7	Улаанбаатар	Бусад
15	0.6	34.5	29.0	4.0	3.3	Улаанбаатар	Бусад
16	0.6	16.5	16.7	5.5	4.0	Улаанбаатар	Бусад
17	0.2	16.6	16.0	6.0	6.0	Улаанбаатар	Чадамжийн төв
18	0.3	15.8	17.5	4.0	6.0	Улаанбаатар	Чадамжийн төв
19	0.0	17.2		5.5		Улаанбаатар	Чадамжийн төв
21	0.8	17.0	17.5	4.0	5.8	Дархан	Бусад
22	0.3	17.5	17.0	4.5	4.5	Дархан	Чадамжийн төв
23	0.6	16.5	17.3	5.5	5.0	Дархан	Бусад
31	0.5	15.7	15.3	5.7	7.0	Дорнод	Бусад
32	0.7	18.0	17.3	5.5	5.0	Дорнод	Чадамжийн төв
41	0.3	16.0	15.5	5.8	6.0	Завхан	Бусад
42	0.3	15.8	15.5	5.8	4.0	Завхан	Чадамжийн төв
51	0.3	16.5	17.5	5.0	4.0	Өмнөговь	Бусад
52	0.3	20.3	19.0	5.3	5.0	Өмнөговь	CDC school